



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/21

Номгон

Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.1, 7.12.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гадны аймгаас отор нүүдэл, үйлдвэрлэл худалдаа, үржлийн болон бусад зорилгоор амьд мал, амьтан зөөвөрлөж тээвэрлэн тус аймгийн нутаг дэвсгэрт байршуулахыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хориглосугай.

2. Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бий болгох, өсвөр хээлтүүлэгч өсгөн бойжуулах, худалдан борлуулах зэрэг ажлыг аймаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан зохион байгуулж, өөрийн аймгийн баталгаажсан үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Малчид, мал бүхий иргэдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгаж халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлж, ард иргэдэд уг захирамжийг танилцуулж мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-эрдэнэ), Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), Цагдаагийн газар (Б.Оюутболд), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601220043